

05 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар****Төрийн үйлчилгээний чиглэлээр:**

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг орон нутгийн засаг захиргаанд хэрэглэх арга зүйн заавар менежментийн тогтолцооны дотоод аудитын 3 хоногийн сургалтыг МЕРИТ төслийн газар болон зөвлөх багш Энхнавч орон нутагт ирж зохион байгуулж 5 төрийн албан хаагч дотоод аудиторын гэрчилгээ авах сургалтанд хамрагдаж шалгалт өгсөн. Аймгийн ХШҮний мэдээллийн цахим санд СЗДҮАХ, сумын хөгжлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээг цаг хугацаанд нь оруулсан.

Хоер: Нийгмийн бодлогын хүрээнд**Нийгмийн халамж:****НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Нийгмийн халамжийн тэтгэвэр 101 иргэнд 28,236,465 төгрөг

Нийгмийн халамжийн тэтгэмж 77 иргэнд 8,776,388 төгрөг

“Цалинтай ээж”-ийн тэтгэмж 273 иргэнд 13,187,156 төгрөг

Жирэмсэн эхийн тэтгэмж 26 иргэнд 1,003,272 төгрөг

Ахмад настны хөнгөлөлт -2 иргэнд 288000 төгрөг

Хүүхдийн мөнгө 1736 хүүхдэд 173,600,000 төгрөгийн олголт хийгдсэн байна.

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг энэ сард 1 удаа хуралдуулж Малжуулах хөтөлбөрт хамрагдах 6 малчин өрхийг сонгон шийдвэрлэсэн.

ХЭБҮ-нд энэ сард 32 өрхийн 153 иргэний 1744,0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

2022 хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар FB: Мөнххаан сумын нэгдсэн зар зарлалын групп цахим хуудсанд мэдээллийг нийтэлсэн.

“Аж ахуй эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрт 14 иргэний төслийг, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих” хөтөлбөрт 4 иргэний төслийг, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрт 1 иргэний төслийг хүлээн аваад ХХҮГазарт хүргүүлсэн байна. “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрт 2-р багийн өндөр настан Л.Нэргүй “Түргэн хоол” чиглэлээр 5,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан.

Мөн төсөлд хамрагдаж буй 9 иргэдэд Профайлинг үйлчилгээг хийсэн.

Бүлгийн ногоонд Зорилтот бүлгийн 10 эмэгтэй бүлэг болон ажиллаж “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төсөлд хамрагдаж иж бүрэн 4*8 хэмжээтэй хүлэмж -2ш, ус нөөцлөх сав -2ш, 50*50 хэмжээтэй газар хаших тор-5ш, 70ш төмөр шонгийн асуудлыг шийдүүлсэн өгсөн.

“Ногоон ажлын байр” хөтөлбөрт 20 иргэн 10 хоногоор 40,000 төгрөгийн цалинтай гэрээ хийн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангийн дансанд 2 иргэн 245.0 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ЕБС: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаарзарлиг, 2021 оны 58 дугаар зарлигаар "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж сумын ойн зурвас байгуулах талбайд багш, ажилчид 300 мод тарьж модны орчим хог чулуу зэргийг цэвэрлэж усалгааг бүрэн хийсэн

05 дугаар сарын 13-ны өдөр 1-р ангийн 3 бүлгийн 104 сурагчдын "Эрдмийн баяр"-ын тайлант өдөрлөг зохион байгуулагдсан.

05 дугаар сарын 18-ны өдөр 5-р ангийн 4н бүлгийн 114 сурагчдын тайлант өдөрлөг зохион байгуулагдсан .

Сүхбаатар аймгийн Өсвөрийн аварга шалгаруулах "Үндэсний бөх"-ийн барилдаанд А.Батхишиг багшийн дасгалжуулсан 7в ангийн сурагч Ч. Төгөлдөр , 5г ангийнсурагч Э.Амартүвшин нар "Тэргүүн" байр эзэлж.Багийн дүнгээр Дэд байр эзэлсэн.

Улсын математикийн 58 дугаар олимпиад зохион байгуулагдаж багш Я.Идэрборгил амжилттай оролцлоо. Өсвөр үеийнхэнд математикийн боловсролыг түгээх үйлсэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж зохион байгуулагчдын нэрэмжит шагнал мөн бодлого бүтэн бодолтын гэсэн 2 шагналаар шагнуулсан.

Улсын Газарзүйн XXVI олимпиадад аймаг сумаа төлөөлөн оролцсон багш О.Санаатүвшин бэлтгэсэн 9в ангийн сурагч Ш.Эрдэнэтунгалагийн хамт, Мөн Олон Улсын логик“**Паззл**” олимпиадын II-даваанд Т.Баярцэцэг багшийн бэлтгэсэн ба ангийн сурагч Б.Эрдэнэбаяр, Т.Сүглэгмаа багшийн бэлтгэсэн 12а ангийн сурагч Э.Энх-Амгалан нар амжилттай оролцлоо.

Монгол хэлний судлагдахуунаас энэ хичээлийн жилийн отгон "НОМТОЙ ӨДӨР"-өө " АДАЛ ЯВДАЛТ, УРАН ЗӨГНӨЛТ" зохиолоор О.Нямсүрэн багштай 11а, Д.Отгонтуяа багштай 11б ангийн оюунлаг сурагчидтай хамтран явууллаа.

Чиглүүлэгч багш Я.Дагиймаагийн удирдсан Монголын скаутын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг УАШТ ур чадварын "Их дуудлага 2022" тэмцээнд 2 дүүргийн 7 аймгийн 210 хүүхдүүд оролцсноос Сүхбаатар Мөнххаан-4 нийт шилдэг 17 салааны 170 гаруй скаутууд оролцсон өргөн цар хүрээтэй тэмцээн 2022.05.07,08ндТөв аймгийн Батсүмбэр сумын "Скаут Эко" зусланд амжилттай болж өндөрлөлөө.

- 🚩 1-р байр "Алтан Цом"-ын эздээр Мөнххаан сумын Нөхөрлөл бүлгэмийн Т.Отгонмөнх ахлагчтай "ZEUS" салаа.
- 🚩 2-р байранд Мөнххаан сумын Нөхөрлөл бүлгэмийн П.Гүрсоронзонгомбо ахлагчтай "Алтан Луужин" салаа.
- 🚩 3-р байранд Дундговь аймгийн Анар ахлагчтай "456" салаа.
- 🚩 4-р байранд Мөнххаан сумын Нөхөрлөл бүлгэмийн Б.Хүрэлтулга ахлагчтай "Нөхөрлөл" салаа.
- 🚩 5-р байранд Мөнххаан сумын Нөхөрлөл бүлгэмийн И.Түвшинбаяр ахлагчтай "Ирээдүй" салаа тус тус шалгарлаа.

Боловсролын чанарын шинэчлэл- 5 төслийн хүрээнд "Сурагчдын уран яруу унших чадварыг хөгжүүлэх" зорилтын хүрээнд 1-3-р анги, 4-5-р ангигэсэн 2 үе шаттай "Уран жиргээ" уран уншлагын уралдааны гамжилттай зохион байгууллаа.Ивээн тэтгэгч: Боловсролын чанарын шинэчлэл -5 төсөл.

2022-2023 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн суралцах СӨБ-ийн Бэлтгэл бүлгийн эцэг эхчүүдэд "Таны хүүхэд сургуульд ороход бэлэн боллоо" сэдвээр эцэг эхийн хамгийн их

асуудаг асуултын хүрээнд мэдээлэл хүргэж ажиллалаа .Хамрагдалт -46% тай байлаа.Бумбаалай цэцэрлэгийн арга зүйч Т.Ариунчимэг болон бэлтгэл бүлгийн багш нартай хамтран ажилласан.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын комиссын бүрэлдэхүүн томилогдож ажлын хэсэг 40%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Хүүхдийн цэцэрлэг: Дотоод үйл ажиллагааны чиглэлээр.

1.1. Арга зүйч энэ сард нийт 15 удаа сургалт үйл ажиллагаанд сууж зөвлөгөө чиглэл өгч ажиллаа. Мөн сургалтын төлөвлөлтийг хэрхэн бичих талаар багш нар зөвлөгөө чиглэл өгч ажиллаа.

1.2. Судар эгшиглэн -2022 төсөлд оролцогч нар энэ сард“Адал явдалт”, “Орчин үеийн сэдэвт” ном уншиж, тэмдэглэлээ цаг хугацаанд нь оруулсан. Багш ажилчдын ном унших болон бичиж тэмдэглэх чадварыг ахиулах зорилгоор цэцэрлэгийн захиргаанаас урамшуулан дэмжиж байгаа. Эхний 14 хоногийн урамшуулалын эзэдээр багш П.Оюунтуяа, туслах багш А.Оюунтуяа, Ц. Азбилэг нар шалгарсан бол 2-р 14 хоногийн хамгийн гоёмсог сайн хийдсэн тэмдэглэлээр арга зүйч Т.Ариунчимэг, өмнөхөөсөө ахисан, сайжирсан, сайн тэмдэглэлээр багш Д.Дэлгэржаргал, нярав А.Зориг нарын тэмдэглэлийг онцолж, урамшуулал олгов.

1.3 Хүүхэд бүрд зөв дадал хэвшлийг багаас нь эзэмшүүлж, зөв монгол хүүхдийг бэлтгэх зорилгоор "Зөв дадал хэвшилтэй - Зөв монгол хүүхэд" үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Нийт 10 бүлэг оролцож хоолой ам зайлах, гар угаах, хувцсаа зөв дараалалаар тайлах, эвхэх, унтаж босоод ороо өөрөө хураах, зөв хооллох, хоолны ширээ засах зэрэг дадал хэвшлүүдийг үзүүллээ. Хүүхдүүд маш сайн дадал хэвшлээ эзэмшиж байна.

1.4 Цэцэрлэгийн заах аргын нэгдлээс зохион явуулсан “Массаар нь хөгжүүлье” үйл ажиллагаанд 19 бүлгийн 201 хүүхдүүд сар бүр оролцож нийтээрээ дуу дуулах, шүлэг унших, дасгал хөдөлгөөн хийх, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсгээр тоглож эцэг эх, асран хамгаалагчиддаа тайлагналаа.

1.5 Ирэх намар сургууль орох 6 настай хүүхдүүдийн эцэг эхтэй “Танай хүүхэд сургуульд ороход бэлэн үү?” уулзалт ярилцлагыг ЕБС-ын бага ангийн менежер Ү.Ариунцэцэгтэй хамтран зохион байгууллаа. Уулзалтанд 66 эцэг эх оролцлоо.

1.6 4 бэлтгэл бүлгийн багш, хүүхдүүд маань СӨБ-ыг 4 жил эзэмшиж “Тайлант өдөрлөг”өө амжилттай зохион байгууллаа. Тайлант өдөрлөгт 94 хүүхэд, 67 эцэг эх оролцлоо.

1.7 Эрхлэгч Д.Ариунмөнх 1 сарын хугацаатай “Удирдлагын манлайлал” сургалтанд хамрагдаж байна.

1.8 "Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм"-ээр багш нар хэлэлцүүлэг хийж, хасах болон нэмэх саналаа БШУ газарт хүргүүлэв.

1.9 “Сүхбаатар аймгийн шилдэг багш , удирдах ажилтан шалгаруулах 2022” уралдаанд оролцох багшаа сонгох үйл ажиллагааг зохион байгуулж, цэцэрлэгээ төлөөлөн оролцохоор Б.Урансайхан багш шалгарлаа.

1.10 “Байгаль нийгмийн орчин” төвийн баяжилтыг хийлээ. Нийт 724 мянган төгрөгөөр багш нар хэрэглэгдүүн авч баяжилт хийсэн. Мөн гар урлалын төрлөөр болон хэвлэмэл материалаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн 220-ыг хийсэн байна.

1.11 Байгууллагын ёс зүйн зөвлөлөөс “БСШУС сайдын 2018 оны А/243-р тушаалыг танилцуулах сургалт хийлээ. Сургалтанд 34 багш ажилчид хамрагдсан.

2. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдлаар.

2.1. Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагаар “ТЭР БУМ МОД” үндэсний хөдөлгөөнд нэгдэн байгууллагаараа 224 суулгалаа.

2.2 Байгууллагын багш ажилчид сум орон нутгийнхаа өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулж “Өрх бүр мод” үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж багш ажилдчид хашаандаа 6- аас дээш тооны мод тарьлаа.

2.3 Сүхбаатар аймгийн нийтийн номын сан, Мөнххаан сумын соёлын төвийн номын сантай хамтран зохион байгуулж буй “Бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагаанд манай цэцэрлэгийн номын сан 156 ширхэг хүүхдийн номоор үзэсгэлэн гаргаж оролцлоо.

2.4 “Сүхбаатар 80 жил” сумдын урлагийн наадамд багш Б.Нандинчимэг, туслах багш Э.Сүхбаатар, М.Мөнхтөр, Ж.Номинчулуун нар амжилттай оролцлоо.

2.5 “Үндэсний номын баяр”-ын хүрээнд шалгаруулсан “Шилдэг уншигч хамт олон байгууллага”-аар шалгарлаа

Соёл: Соёлын төв 05 дугаар сард:

- Ирсэн бичиг - 9
- Явсан бичиг - 3
 - Хариутай бичиг – 3
 - Хугацаандаа явсан бичиг – 3
 - Хугацаа болоогүй бичиг – 1
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1 Удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу 9 албан бичиг хүлээн авч хариутай 3 бичгийн хариуг барагдууллаа. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтээр мод тарих аяны хүрээнд сумын нийтийн эзэмшлийн газарт 50 ширхэг модыг тарьж усалгаа хийж арчилгаа тордлогыг хийн ажиллаж байна. Мөн байгууллагын гадна орчинд 5 төрлийн цэцгийн мандлыг үрслүүлж суулган өрөө тасалгаанд 25 савтай цэцгийг тарьж ургуулах ажлыг хийгээд байна \ХАБЭА сарын аяны хүрээнд байгууллагад ХАБЭА ажилтны буланг байршуулан мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

1.2 Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу урлагийн наадам зохион байгуулах сумын засаг даргын 2022.04.02-ны өдрийн А\59 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг урлагийн наадамд 33 уран бүтээлч, арын албанд 15 төрийн албан хаагчид нийт 48 хүний бүрэлдэхүүнтэй Сүхбаатар аймагт 2 өдөр Биеийн тамир спортын газар байрлуулж хуваарийн дагуу Урлагийн наадмын бэлтгэл хийж 5-6-нд Сүхбаатар 80 урлагийн наадамд “Дуурсах алдартай Мөнххаан” тоглолтоороо Тэргүүн байр эзэлж амжилттай оролцлоо.

1.3 Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдсан “Илүү их уншья” бичиг үсгийн баярын нэгдсэн арга хэмжээнд номын санч Б.Отгонтуяа оролцлоо.

1.4 Бичиг соёлын өдрүүдийг сумандаа 5 сарын 27-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

1.5 Аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын 17-ны өдрийн 1\486 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын даргын тушаалаар тооллого зохион байгуулах комиссыг томилж байгууллагын үндсэн хөрөнгийг тоолох тооллогын ажил эхлээд байна.

1.6 Соёлын төвийн үйл ажиллагааны өдөр тутмын бүртгэлийн дэвтэр боловсруулах төслийн дагуу үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх засаж сайжруулах саналыг нэгтгэн ажиллаж байна.

1.7 Дорнод аймгийн Соёл урлагийн газар, Соёлын төвийн дарга нарын 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Мөнххаан сумын соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага судалж хамтран ажилласан .

- 1.8 5-р сард соёл урлагийн нэгдсэн 3 арга хэмжээ, номын сангийн чиглэлээр 4 арга хэмжээ, соёлын өвийн чиглэлээр 5 арга хэмжээ гадны тоглолт түрээсийн арга хэмжээ 2, бусад байгууллага багийн арга хэмжээ 5 нийт 19 арга хэмжээ зохион байгуулагдаад байна.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

5-р сард өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого 870.0 түрээсийн орлого 450.0 нийт 1320.0 төгрөгийн орлого төвлөрүүлэлтийг хийж нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулсан. 5 сарын 20-нд төсвийн сарын хуваарийн санхүүжилтээ авч сарын гүйлгээг хийж байна. Засаг даргын нөөцөөс урлагийн наадамд 11000.0 соёлын төвийн уран бүтээлийн зардлаас 3000.0 ард иргэд төрийн болон төрийн бус байгууллага, ААН-ээс хоол хүнсний зардалд 5.000.0 нийт 19.000.0 төгрөг зарцуулагдсан байна. 2023 онд хэрэгжүүлэх төсвийн саналыг СУГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1 Номын сангийн танхимын үйлчилгээгээр 210 иргэд, хүүхэд багачуудад 606 ширхэг номоор, зөөврөөр 12 иргэнд 29 номоор нийт 222 иргэнд 635 номоор үйлчилсэн байна.

3.2 Сумын Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлөөс 5 сая төгрөгийн 266 нэр төрлийн номоор шинэ номын баяжилтыг хийж бүртгэлд оруулан шинэ номын үзэсгэлэнг зохион байгуулан 5 сарын 26-нд Бичиг соёлын өдөр номын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

ЕБС-ийн сурагчдын дунд “ Хүрэл тулга ” наадмыг зохион байгуулж нийт 18 сурагчид оролцлоо. Соёлын олон талт арга хэмжээнд нийт 1123 гаруй үйлчлүүлэгчдийг хамруулсан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2022 оны 05 сарын 25-ны байдлаар 57өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 28 насанд хүрэгчид, 29 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

“Идэвхтэй илрүүлэлтийг чанартай зохион байгуулж сүрьеэг илрүүлье” 1 сарын аян зохион байгуулж СЭМХолбооноос сүрьеэгийн талаарх идэвхтэй илрүүлэлт, зохион байгуулж буй ажлын талаар дэмжлэг хяналт хийсэн.

6-59 сартай хүүхдүүдэд А аминдэм уулгаж ач холбогдлын талаар эцэг эхчүүдэд мэдээлэл сургалтыг тогтмол хийж байна. Одоогоор 120 хүүхдэд А аминдэм уулгасан.

“В гепатит вирусээс сэргийлье” сургалтын материал бэлдэж 12 ангийн сурагчдад сургалтыг зохион байгуулсан.

“Элэгний хөтөлчийн сайн дурын идэвхтэн 9 хүн баг бүрдүүлэн ажиллаж байна. 5 сарын 27 өдөр баруун бүсийн буюу 4 сумын сайн дурын идэвхтэн сургалт манай суманд зохион байгуулагдана.

Эрт илрүүлэг үзлэг шинжилгээг анхан шатны маягтыг захиалан зохион байгуулж байна. Үүнд: 6-17 насны 35 хүүхэд хамрагдаад байна.

Амбулаторийн үзлэг 721 , урьдчилан сэргийлэх үзлэг 253 байна.

Түргэн тусламжийн дуудлага 42 ирснээс алсын дуудлага–12, ойрын дуудлага30 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Гурав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд үхэр 34000 мян, тугал 14000 мян бүгд 48000 мянган толгой үхэр хамруулахаас үхэр 30120 мян , тугал 10120 мян толгой бүгд 40240 мян толгой үхэр эрүүлжээд байна. 672 өрхийн. Мал эмнэлгийн гарал үүслийн 44 гэрчилгээгээр адууны мах 5938 кг, үхэрийн мах 130 кг, хонины мах 35850 кг , ямааны мах 6260 кг бүгд 48178 кг мах зах зээлд борлуулалт хийсэн байна.

Дөрөв: Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Сумын засаг даргын 2022 оны 04 сарын 20-ны өдрийн А/68 тоо захирамжийн дагуу “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-ний ажлыг 7 хонгийн хугацаанд нэгдсэн зохион байгуулалттайгаар гудамж, эгнээ байр, нийтийн эзэмшлийн газруудад иргэд айл өрх, төсөвт 5-н байгууллага, 17-н аж ахуй нэгжүүд хамтран ажилласан. Үүнд 85 тн хог хаягдлыг зайлуулж, шатах тослох материалын 473850 төгрөгийн зардал гарсан.

Хоёр: Ногоон байгууламжийн талаар Суманд одоогийн байдлаар 2800 ш мод тариад байна. Нөхөн сэргээлтээр ногоон байгууламжинд 125ш хайлаас, ойн зурвас байгуулж 1000 ш хайлаас, улиас 5 байгууллага 215 мод тарьж суулгасан. Сумын ойн зурвасыг хашаажуулах моджуулах ажилд 50,0 гаруй сая төгрөгийн зардал гарсан.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

1 арга хэмжээний 6 нэгж талбарт иргэдээс хүсэлт авч, өргөдлийн дагуу кадастрийн холболт хийн шийдвэрлэх, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан . ГЗТөлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбар тус бүрээр газар өмчлөлийн өргөдлийг иргэдээс авч хуулийн дагуу шийдвэрлэж нийт 67 иргэний өмчлөлийн асуудлыг шийдлээ

ГЗБТөлөвлөгөөнд тусгагдсан 6 нэгж талбарт газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж дууссан. Дуудлага худалдаанд ялсан иргэдтэй гэрээ байгуулах шатанд явж байна.

Бусад ажлын хүрээнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэл 50%-тай явж байна.

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд: Суманд ойн зурвас байгуулах ажлыг ЗДТГ-ын албан хаагчид 1,5 км газрыг хашаажуулж ,шонг суулгах, модны нүх ухах, мод суулгах , хайлаас улиас суулгац худалдан авах зэрэг ажлыг байгаль хамгаалах зардлаас 50,0 гаруй сая төгрөгийн зардлыг гарган 10 хоног ажиллаж хийгдсэн .

Шинээр ногоон байгууламж 1-ийг байгуулж хашаажуулж мод бут суулгах ажлыг эхлүүлээд байна.

